



БОГД БАНК
ХУВЬЦААТ КОМПАНИ

БОГД БАНКНЫ ТОС-ЫН АЖЛЫН ХЭСЭГ

2024

2-Р УЛИРЛЫН ТАЙЛАН

www.bogdbank.com



ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛГО

Богд Банк нь байгаль орчинд ээлтэй, нийгмийн хариуцлагаа ухамсарласан, ил тод үйл ажиллагаа явуулахыг эрхэмлэдэг билээ. Бид өөрсдийн санхүүжүүлэх төсөлд ч энэхүү шалгуурыг тавьж, дэмжин ажилладаг бөгөөд уг зорилгын хүрээнд Монгол Улсын Тогтвортой санхүүжилтийн (ТоС) хөтөлбөрт нэгдэн орж, 2015 оноос ТоС хөтөлбөрийн албан ёсны гишүүнээр элсэн орсон. Түүнээс хойш Богд банк өдөр тутмын үйл ажиллагаа болон бүтээгдэхүүн үйлчилгээндээ тогтвортой хөгжлийн зорилтуудыг үргэлж тусгаж ирсэн.



НОГООН САНХҮҮЖИЛТ

Бид тайлант хугацаанд Азийн Хөгжлийн Банк (АХБ), Богд Банк ХК Монгол Улсын бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчдэд зориулсан санхүүжилтийг нэмэгдүүлэх, тэр дундаа бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн болон ногоон зээлийг дэмжих зорилгоор 15 сая ам.долларын зээлийн гэрээнд гарын үсэг зурлаа. АХБ-наас олгох ба үүний талыг бичил, жижиг, дунд бизнес эрхлэгч эмэгтэйчүүдэд зориулах юм. Үлдсэн 1 сая ам.долларыг АХБ-ны удирдаж буй Канадын Азийн Хувийн Секторт зориулсан Уур Амьсгалын Хоёрдугаар Сангаас санхүүжүүлнэ. Тус сангийн хөнгөлттэй зээлийг АХБ-ны зээлтэй хослуулж (blended) эрчим хүчний хэмнэлттэй тоног төхөөрөмж худалдан авах, бага оврын сэргээгдэх эрчим хүчний суурилуулалт хийх зэргээр бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчдэд зориулсан уур амьсгалын санхүүжилтыг дэмжихэд зарцуулах юм.



НОГООН ОРЧИН

Богд банк нь “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд СХД-ийн Бумбатын булагт тарьж байсан модоо услах, нөхөн сэргээх ажлыг хийлээ. Манай улс жил бүрийн 5 болон 10 дугаар сарын 2 дахь долоо хоногийн Бямба гараг бүрийг бүх нийтээр мод тарих үндэсний өдөр болгосонтой холбоотой Тэрбум мод үндэсний хөдөлгөөний дэмжих сангаас 5 сарын 12-ны өдөр Монгол банк, Монголын банкны холбоо болон арилжааны банкуудтай хамтран Гачууртын Олон улсын эко цэцэрлэгт хүрээлэнд 14 га газарт 1000 гаруй модны тарьц суулгалаа. Банк санхүүгийн салбарын төлөөлөл 2030 он гэхэд 50 сая мод тарих зорилт тавьсан бөгөөд үүний хүрээнд жил бүр шинээр мод тарих, өмнө нь тарьсан модоо услах, арчлах ажлыг тогтмол хийж байна. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг амжилттай хэрэгжүүлснээр ойн сан нэмэгдэж, хүлэмжийн хийн ялгарал буурахаас гадна нийгэм, эдийн засгийн олон асуудлыг шийдвэрлэхэд эерэг нөлөө үзүүлэх юм.


Богд банк нь байгаль орчин, нийгэмд ээлтэй бүхийл үйл ажиллагааг дэмжин ажиллаж, харилцагч нартаа ногоон бүтээгдэхүүн үйлчилгээг санал болгож байна.



НӨӨЦИЙН ХЭМНЭЛТ

Бид нөөцийн хэмнэлтийн хүрээнд жил бүр шинэ санаа санаачилгыг гарган ажиллахыг зорин ажилладаг бөгөөд, бид тайлант хугацаанд харилцагчдадаа бэлэглэх гарын бэлгэнд цаасны хэрэглээ, хог хаягдлыг бууруулах үүднээс олон удаагийн хэрэглээний аягыг сонгон бэлэглэдэг.

Мөн Банк нь олон нийтэд зориулсан өөрийн сүлжээгээр “Уур амьсгалын өөрчлөлт”, “Хүлэмжийн хий”, “Усны хэмнэлт”, “Хог хаягдал”, “Байгаль орчноо хайрлан хамгаалах”-тай холбоотой уриалга мэдээллийг тухай бүр хүргэн ажиллаж байна




ИЛ ТОД БАЙДАЛ

Мөн энэ оноос эхлэх бид хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах зорилгоор үйл ажиллагаандаа Цахилгаан автомашин нэвтрүүлээд байна. Цахилгаан автомашин үйл ажиллагаандаа нэвтрүүлсэнээр дээрх 2023 оны 16,111.2 кг хүлэмжийн хийг хэмнэх боломжтой болсон билээ.

$$\sum \text{автомашинны ялгаруулалт}_x = \frac{\sum \text{Шатахууны зардал}_x}{\text{1л шатахууны үнэ}} \times \text{Ялгаруулалтын коэффициент}$$

Богд банканд ашиглагдаж буй автомашинуудаас гарсан хүлэмжийн хийн ялгарлыг 2023 оны хугацаанд дээрхи томъёогоор тооцоолоход нийт 16,1 тонн хүлэмжийн хий ялгаруулсан байна.



Цаашид автомашин тус бүрээр ялгарал тооцох тухайн хугацааны эхэнд болон сүүлд явсан км-ыг тэмдэглэж нийт явсан км-ыг машин тус бүрийн шатахуун зарцуулалтын нормоор үржүүлж бодох нь илүү оновчтой тооцоолол болно гэж үзэж байна.

